

МОНГОЛ, ЯПОНЫ СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР (2017-2021 ОН)

I. Улс төр, аюулгүй байдлын салбарын хамтын ажиллагаа: Монгол, Японы харилцааг цаашид улам гүнзгийрүүлэн хөгжүүлж, бүс нутгийн тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийн төлөөх түншлэлийг бэхжүүлнэ.

1. Улс төрийн харилцаа

Өнөөг хүртэлх ололт амжилтууд

Монгол Улс, Япон Улсын хооронд (цаашид "хоёр улс" гэх) Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Япон Улсад таван удаа, Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ Монгол Улсад гурван удаа айлчлах зэргээр дээд, өндөр түвшний айлчлалын давтамж сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэв. Нэн ялангуяа Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Ерөнхий сайд Ш.Абэ нар нийт 9 удаа уулзсан нь бүс нутгийн орлуулшгүй түнш хоёр улсын харилцааг урагшлуулан хөгжүүлэхэд түлхэц болж, харилцан итгэлцлийг бэхжүүлэв.

Хоёр улсын Гадаад харилцааны сайд нар 2013, 2014 болон 2016 онд уулзав. Гадаад харилцааны яамд хооронд Стратегийн зөвлөлдөх уулзалтыг дэд сайдын түвшинд 2014 оноос зохион байгуулсан нь нэн чухал ач холбогдолтой болов.

Хоёр улсын салбарын яамд, газруудын харилцаа идэвхжиж, өндөр түвшинд харилцан айлчлах, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, зөвлөлдөх уулзалт тогтмол зохион байгуулах зэргээр эрчимтэй өрнөж, хоёр улсын харилцаа өргөжин хөгжиж байна.

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

(1) Монгол Улс, Япон Улсын Засгийн газар (цаашид "хоёр улсын Засгийн газар" гэх) хоёр орны улс төрийн харилцан итгэлцлийг улам бэхжүүлж, дээд түвшний харилцан айлчлал, өндөр түвшний яриа хэлцээний давтамжийг хадгална. Мөн дээд түвшинд тогтоосон бат бэх итгэлцэл, найрсаг харилцааг цаашид ч гүнзгийрүүлнэ.

(2) Хоёр улсын Засгийн газар Гадаад харилцааны сайд нарын уулзалтыг хоёр улсын аль нэгэнд, эсвэл НҮБ-ын Ерөнхий Ассамблей болон олон улсын бусад хурал, чуулганы үеэр жилд нэг болон түүнээс дээш удаа зохион байгуулж ирсэн уламжлалаа хадгална.

(3) Хоёр улсын Засгийн газар бүх төрлийн яриа хэлцээг өрнүүлж, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх үүднээс хоёр улсын Парламент болон Парламент дахь найрамдлын бүлэг хоорондын харилцаа, хамтын ажиллагааг дэмжиж ажиллана.

(4) Хоёр улсын Засгийн газар ГХЯ-д хоорондын Стратегийн зөвлөлдөх уулзалтыг тогтмол зохион байгуулж, хоёр талын харилцаа, бүс нутгийн аюулгүй байдал зэрэг өргөн хүрээтэй, стратегийн шинж чанартай асуудлаар санал солилцоно. Мөн Монгол Улсын Засгийн газрын урилгаар Япон Улсын ГХЯ-ны дунд шатны дипломат ажилтнуудыг урих хөтөлбөрийг тогтмолжуулах зэргээр ГХЯ хоорондын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

(5) Хоёр улсын Засгийн газрын холбогдох яам, агентлагуудын хооронд бүхий л төрлийн стратегийн болон бодлогын зөвлөлдөх уулзалт, бусад хэлбэрийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

(6) Монгол Улсын Засгийн газар Япон Улсын идэвхтэй, энх тайванч гадаад бодлогыг дэмжинэ.

2. Аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа

Өнөөг хүртэлх ололт амжилтууд

Хоёр улсын Засгийн газар аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлж, тус салбар дахь хоёр улсын бодлогын талаарх харилцан ойлголцлыг гүнзгийрүүлж, Нэгдсэн Үндэстний байгууллагын энхийг сахиулах ажиллагаа (цаашид “НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа” гэх)-ны хүрээнд хамтын ажиллагаагаа бэхжүүлэв.

Хоёр улсын гадаад бодлого, батлан хамгаалах, аюулгүй байдлын холбогдох байгууллагын бодлогын зөвлөлдөх уулзалтыг 2013 оны 1 дүгээр сараас хойш гурван удаа зохион байгуулж, бүс нутаг, олон улсын байдал зэрэг асуудлаар үр дүнтэй санал солилцов.

2012 онд гарын үсэг зурсан “Монгол Улсын Батлан хамгаалах яам, Япон Улсын Батлан хамгаалах яам хоорондын батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг”-т тулгуурлан өргөн хүрээнд хамтран ажиллаж ирэв.

Хоёр улсын Засгийн газар Батлан хамгаалахын сайд нарын уулзалтыг 2014, 2015 онд, дэд сайд нарын уулзалтыг 2013 оноос хойш зохион байгуулж байна. Мөн Батлан хамгаалах яамд хоорондын ажил хэргийн түвшний уулзалтуудыг

тогтмол зохион байгуулж ирэв. Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхийг бэхжүүлэх хамтын ажиллагааны хүрээнд 2012 оноос эрүүл ахуй, барилга байгууламжийн салбарт “Чадавхийг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлж ирэв. 2015 онд “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулагдав. Уг хэлэлцээрт үндэслэн Япон Улсын Засгийн газар Монголын Зэвсэгт хүчний барилга, инженерийн чадавхийг дээшлүүлэх чиглэлд гурван жилийн хугацаанд дэмжлэг үзүүлэв.

Монгол Улсын санаачилгаар зохион байгуулагддаг “Хааны эрэлд” олон улсын хамтарсан хээрийн сургуульд Япон Улсын Өөрийгөө хамгаалах хуурай замын хүчин 2009 оноос сургагч нарыг, 2015 оноос сургалтын баг оролцуулж байна.

Японы Батлан хамгаалахын Их сургууль монгол оюутнуудыг тогтмол хүлээн авч сургаж байна.

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

(1) Хоёр улсын Засгийн газар гадаад бодлого, батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн байгууллага хоорондын зөвлөлдөх уулзалтыг үргэлжлүүлэн тогтмол зохион байгуулна.

(2) Хоёр улсын Засгийн газар “Монгол Улсын Батлан хамгаалах яам, Япон Улсын Батлан хамгаалах яам хоорондын батлан хамгаалах салбарт хамтран ажиллах санамж бичиг”-т үндэслэн өндөр, ажил хэргийн түвшний харилцан айлчлалуудыг хэрэгжүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэхийн зэрэгцээ БХЯ-дын Зөвлөлдөх уулзалтыг тогтмол зохион байгуулна. Түүнчлэн хоёр улсын Засгийн газар бүс нутаг, олон улсын аюулгүй байдал, терроризм, хүмүүнлэгийн тусламж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа зэрэг сэдвээр харилцан сонирхсон асуудлаар цаашид ч санал солилцоно. Мөн анги, нэгтгэлүүд хоорондын солилцоо, батлан хамгаалах салбарын сургалт, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлнэ. Үүний зэрэгцээ олон улсын хурал, хээрийн сургуульд идэвхтэй оролцох зэргээр энэ чиглэлийн олон талт хамтын ажиллагааг улам эрчимжүүлнэ.

(3) “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн дагуу Япон Улсын Засгийн газар Монголын Зэвсэгт

хүчний чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг цаашид ч бэхжүүлнэ.

3. Бүс нутаг, олон улсын тавцан дахь хамтын ажиллагаа

Өнөөг хүртэлх ололт амжилтууд

Эрх чөлөө, ардчилал, эрх зүйт төрийг эрхэмлэдэг бүс нутгийн түнш орнуудын хувьд бүс нутаг, олон улсын тавцанд ч хоёр улс хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлсээр ирэв.

Хоёр улсын Засгийн газар бүс нутаг, олон улсын тавцан дахь тус тусын гадаад бодлого, үйл ажиллагааг харилцан хүндэтгэж, дэмжиж ирэв. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар Япон Улсыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүн болохыг тууштай дэмжиж ирсэн. Япон Улсын Засгийн газар Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг олон улсын тавцанд хүлээн зөвшөөрүүлэх асуудлыг тууштай дэмжиж ирсэн.

Хоёр улс Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгах, Зүүн хойд Азийн энх тайван, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хамтын ажиллагааны хүрээнд “Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилга зэрэг бүхий л түвшний уулзалт, яриа хэлэлцээгээр дамжуулан санал, мэдээлэл солилцон нягт уялдаа холбоотой хамтран ажиллаж ирсэн. Хулгайлагдсан япон иргэдийн асуудал зэрэг шийдвэрлэгдээгүй маргаантай асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх ёстой гэсэн Япон Улсын байр суурийг Монгол Улс дэмжиж ирсэн.

Мөн 2015 оны 9 дүгээр сард Монгол Улс, Япон Улс, АНУ-ын гурван талт уулзалтыг зохион байгуулж, Зүүн хойд Азийн бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхээр ярилцав. Япон Улс болон АНУ-ын зүгээс Монгол Улсын эдийн засгийн шинэчлэлийг цаашид ч тууштай дэмжихээ энэ үеэр нотлов.

Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлд болон халимны нөөцийг зүй зохистой ашиглах асуудлаар хоёр улсын Засгийн газар олон улсын тавцанд уялдаа холбоотой хамтран ажиллаж ирэв.

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

(1) Хоёр улсын Засгийн газар олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах хүрээнд хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийн хамт НҮБ-ын Аюулгүйн

Зөвлөлийн шинэчлэлийн асуудлаарх Засгийн газар хоорондын яриа хэлэлцээг эрчимжүүлж, уг шинэчлэлийг ойрын хугацаанд хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллана. Япон Улс НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болохыг Монгол Улсын Засгийн газар цаашид ч тууштай дэмжинэ.

(2) Хоёр улсын Засгийн газар бүс нутаг, олон улсын хамтын нийгэмлэгийн энх тайван, тогтвортой байдлын төлөө хамтран ажиллахаа нотолж, Япон Улсын Засгийн газар Ази, Номхон далайн бүс нутаг, ялангуяа Зүүн Азийн олон талт хамтын ажиллагааны механизмд нэгдэн орох Монгол Улсын хүсэл эрмэлзлэлийг үргэлжлүүлэн дэмжинэ.

(3) Япон Улсын Засгийн газар Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг олон улсын тавцанд хүлээн зөвшөөрүүлэх чиглэлд үргэлжлүүлэн хамтран ажиллана. Монгол Улс цөмийн зэвсгээс ангид байх статусаараа дамжуулж аюулгүй байдлаа улс төр, дипломат арга замаар бэхжүүлэх үзэл баримтлалд үндэслэн олон улсын тавцанд гаргаж буй хүчин чармайлтыг Япон Улсын Засгийн газар үнэлж, Монгол Улсын Засгийн газрын цаашдын үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжинэ. Мөн хоёр улсын Засгийн газар олон улсын тавцан дахь цөмийн зэвсэг хураах, үл дэлгэрүүлэх үйл ажиллагаа, ялангуяа 2020 онд болох Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх Гэрээний хэрэгжилтийг хянан хэлэлцэх Бага хурлыг амжилттай зохион байгуулах чиглэлд хамтран ажиллана. Хоёр улсын Засгийн газар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн нэгдүгээр хороонд нягт хамтран ажиллана.

(4) Хоёр улсын Засгийн газар Хүний эрхийн зөвлөлийн гишүүн улсуудын хувьд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр хамтран ажиллана.

(5) Хоёр улсын Засгийн газар олон улсын эрх зүйн зарчимд бүрэн нийцүүлэн энх тайван, тогтвортой байдал ба хөгжил цэцэглэлтийг хангах, далайн аюулгүй байдал, хамтын ажиллагаа, далайд чөлөөтэй зорчих, түүний дээгүүр нислэг үйлдэх, хууль ёсны худалдааг ямар ч саадгүй хийх байр сууриа дахин нотолж, эдгээр чиглэлийн хамтын ажиллагааг дэмжинэ.

(6) Хоёр улсын Засгийн газар Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгаж, Зүүн хойд Азийн энх тайван, тогтвортой байдлыг хангах хүрээнд Умард Солонгос цөм, баллистик пуужингийн хөтөлбөрөөс бүрмөсөн татгалзаж, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоол болон зургаан талт яриа хэлэлцээний Хамтарсан мэдэгдлийг мөрдөхийг уриална. Хулгайлагдсан япон иргэдийн зэрэг шийдвэрлэгдээгүй, маргаантай асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх ёстой гэсэн Япон Улсын байр суурийг

Монгол Улс дэмжиж буйгаа нотлов. Япон Улсын Засгийн газар Монгол Улсын дэвшүүлсэн “Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачлагыг хэрэгжүүлэх, Умард Солонгосыг тойрсон маргаантай асуудлуудыг шийдвэрлэх, Зүүн хойд Ази дахь энх тайван, тогтвортой байдлыг хангах чиглэлээр баримталж буй Монгол Улсын Засгийн газрын байр суурийг дэмжинэ.

(7) Хоёр улсын Засгийн газар Монгол, Япон, АНУ-ын гурван талт уулзалтыг Монгол Улсын санаачилгаар тогтмол зохион байгуулах чиглэлд үргэлжлүүлэн хамтран ажиллана.

(8) Хоёр улсын Засгийн газар терроризм, хэт даврах үзлийн эсрэг олон улсын уулзалт, арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажиллаж, олон улсын терроризмын асуудлаарх хамтын ажиллагааг үргэлжлүүлнэ.

(9) Хоёр улсын Засгийн газар гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бүс нутаг болон олон улсын тавцанд үргэлжлүүлэн уялдаа холбоотой ажиллана.

(10) Хоёр улсын Засгийн газар халим зэрэг загас агнуурын нөөцийг тогтвортой ашиглах чиглэлд олон улсын тавцанд үргэлжлүүлэн уялдаа холбоотой хамтран ажиллана.

II. Эдийн засгийн харилцаа: Монгол Улсын эдийн засгийг сэргээн хөгжүүлж, хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

1. Монгол Улсын макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг тууштай хэрэгжүүлж, Монгол Улсын хөрөнгө оруулалт, бизнесийн орчинг бэхжүүлнэ.

Өнөөг хүртэлх ололт амжилтууд

Хоёр улсын Стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр 2016 оны 6 дугаар сард хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхлэв. Мөн хоёр улсын эдийн засгийн харилцааны өргөн цар хүрээтэй асуудлуудыг хэлэлцэх талбар болох Монгол, Японы төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалт долоон удаа зохиогдов.

2014 оны 7 дугаар сараас хэрэгжүүлж буй “Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл” зэрэг техникийн хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй

болгох чиглэлд Япон Улсын Засгийн газар дэмжлэг үзүүлж, сургалт, семинар зохион байгуулж, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинг бүрдүүлж, чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулав. Мөн Монголын хөрөнгө оруулалт, бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр хийсэн судалгааны хүрээнд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас Японы бизнес эрхлэгчдэд зориулсан гарын авлага хэвлэж гаргав.

2013 оны 12 дугаар сард Японы хөрөнгийн зах зээл дээр Монгол Улсын Хөгжлийн банк 30 тэрбум иенийн самурай бонд босгоход Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банк баталгаа гаргав. Ингэснээр Монгол Улсын Засгийн газар болон Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэж, Японы хувийн хэвшлийнхэнд хөрөнгө оруулалтын шинэ боломж нээгдэв.

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

(1) Монгол Улсын Засгийн газар “Эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөр”-ийг баттай хэрэгжүүлнэ. Олон улсын валютын сан (ОУВС)-ийн шугамаар батлагдсан олон улсын санхүүгийн дэмжлэг үзүүлэх багцыг Япон Улсын Засгийн газар үнэлж, энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газар эдийн засаг, санхүүгийн хүндрэлийг даван туулах, эдийн засгийн дунд болон урт хугацааны өсөлт, тогтвортой байдлыг хангахад хамтарч ажиллана.

(2) Хоёр улсын Засгийн газар Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр зэрэг хоёр орны хооронд байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нягт уялдаа холбоотой хамтран ажиллана. Монгол Улсын Засгийн газар Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн бодитой хэрэгжилтийг хангахад шаардлагатай хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллана.

(3) Хоёр улсын Засгийн газар Давхар татварын хэлэлцээр байгуулах асуудлаар ажил хэргийн түвшний яриа хэлэлцээг эрчимтэй өрнүүлж, хөрөнгө оруулалт, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд тааламжтай агуулга бүхий тохиролцоонд хүрэх чиглэлээр ажиллана.

(4) Хоёр улсын Засгийн газар Монгол, Японы төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтыг үргэлжлүүлэн зохион байгуулж, уулзалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ. Монгол Улсын Засгийн газар төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтын үр дүнд тулгуурлан Монгол Улсын бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр дэх хоёр улсын хувийн хэвшлийнхний оролцоо болон бизнесийн солилцоог хөхиүлэн дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалтын тогтвортой

орчинг бүрдүүлнэ.

(5) Хоёр улсын худалдаанд учирч буй саад тотгорыг багасгах үүднээс Монгол Улсын Засгийн газар өөрийн хоёр хөрш улстай транзит тээврийг саадгүй явуулах орчинг бүрдүүлнэ.

(6) Япон Улсын Засгийн газар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн эрх зүйн тогтолцоог бэхжүүлж, хөрөнгө оруулагчдыг сургахад хамтран ажиллана.

(7) Япон Улсын Засгийн газар Монгол Улсын хүн амын хөгжил, нийгмийн даатгалын салбарын чадавхийг бэхжүүлэхэд нийгэм хамгааллын салбарт үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

(8) Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2013 онд босгосон самурай бондод Японы Олон улсын хамтын ажиллагааны банк (ЖБИК)-аас гаргасан баталгаа 2023 он хүртэл үргэлжлэхийг Япон Улсын Засгийн газар анхааралдаа авав.

2. Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа

Өнөөг хүртэлх ололт амжилтууд

Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд өнөөг хүртэл хоёр улс олон чиглэлд хамтын ажиллагааг өрнүүлж ирэв.

Хоёр улсын хооронд харилцан ашигтай эдийн засгийн харилцааг хөгжүүлэх зорилгоор 2015 оны 6 дугаар сард Монгол Улсын Аж үйлдвэрийн яам, Япон Улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам хооронд "Аж үйлдвэр, худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хамтын ажиллагааны санамж бичиг" байгуулав.

Япон Улсын Засгийн газрын иенийн хөнгөлөлттэй зээлээр хоёр удаа хэрэгжсэн "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл"-өөр Монгол Улсын хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний зэрэг салбарт нийт 600 гаруй аж ахуйн нэгжид зээл олгогдож, төслийн үр дүнд Монгол Улсад арван мянга орчим ажлын байр шинээр бий болов. Мөн жижиг, дунд үйлдвэрийн санхүүгийн тогтолцоог дэмжих үүднээс зээлийн батлан даалтын сангийн боловсон хүчинг бэлтгэхэд Япон Улс дэмжлэг үзүүлэв.

2014 оны 3 дугаар сард байгуулсан иенийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд "Инженер, технологийн дээд боловсрол" төсөл хэрэгжиж байна. Мөн Япон

Улсын “КООСЭН”-гийн сургалт буюу инженер, технологийн мэргэжлийн боловсрол олгох сургалтын тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг эхлүүлж, “Монгол, Японы хүний нөөцийн хөгжлийн төв”-д бизнесийн салбарын хүний нөөцийг бэлтгэн сургах үйл ажиллагааг явуулах зэргээр Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын боловсон хүчинг бэлтгэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарт малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зэрэгт чиглэсэн өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хэрэгжүүлэв. Уул уурхайн салбар дахь хүний нөөцийг хөгжүүлэх хамтын ажиллагааг урагшлуулж, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн үндэс суурийг бэхжүүлэхэд хамтран ажиллав.

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

(1) Япон Улсын Засгийн газар Монгол Улсын инженер, технологийн дээд боловсролын байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, Япон Улсад оюутан сургах, “Монгол, Японы хүний нөөцийн хөгжлийн төв”-өөр дамжуулан аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. Түүнчлэн мэргэжлийн бүхий л салбар дахь хүний нөөцийг хөгжүүлэх үүднээс мэргэжлийн боловсрол, сургалтын хугацаанд суралцагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг Монгол Улсын мэргэжлийн боловсрол олгох сургалтын тогтолцоотой уялдуулж хэрэгжүүлэх боломжийг судалж, дэмжлэг үзүүлнэ.

(2) Хоёр улсын Засгийн газар Япон Улсад “Ур чадварын дадлагыг зүй зохистой хэрэгжүүлэх, ур чадварын дадлагажигчдыг хамгаалах тухай хууль” шинээр батлагдсантай холбогдуулан ур чадварын дадлага эзэмшүүлэх тогтолцоог Монгол Улсын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг бүхий хүний нөөцийг хөгжүүлэхэд хөшүүрэг болгох зорилтын хүрээнд холбогдох баримт бичгийг аль болох ойрын хугацаанд байгуулна.

(3) Япон Улсын Засгийн газар Монгол Улсын барилгын салбарт барилгын талбай дахь аюул ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах салбарт хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

(4) Япон Улсын Засгийн газар Монгол Улсын уул уурхайн салбарын боловсон хүчинг бэлтгэхэд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ.

(5) Хоёр улсын Засгийн газар Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжинэ. Япон Улсын Засгийн газар олон улсын байгууллагын дэргэдэх Японы итгэлцлийн сангаар дамжуулан Монгол Улсад дэмжлэг үзүүлэх зэргээр хамтран ажиллана.

(6) Япон Улсын Засгийн газар Монгол Улсын Засгийн газартай Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, мал эмнэлэг, мал аж ахуйн салбар дахь боловсон хүчинг бэлтгэхэд үргэлжлүүлэн хамтран ажиллаж, шүлхий өвчин зэрэг мал, амьтны хил дамнасан халдварт өвчний эсрэг авах арга хэмжээ, эрүүл ахуй, ургамал хорио цээрийн салбарын хамтын ажиллагааг урагшлуулж, улмаар хөдөө аж ахуйн гаралтай эцсийн бүтээгдэхүүнийг Японы зах зээлд нийлүүлэх асуудлаар санал, мэдээлэл солилцож ажиллана.

(7) Хоёр улсын Засгийн газар иенийн хөнгөлөлттэй зээлийн хоёр үе шаттай төслийн эргэлтийн хөрөнгөөр жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр нягт хамтран ажиллана.

(8) Монгол Улсын “Шинэ төмөр зам” төслийн хүрээнд баригдах Таван толгой-Сайншанд, Сайншанд-Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих төслийг Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөр”-т заасан төсвийн бүтцийн хүрээнд судалж үзнэ. Хоёр улсын Засгийн газар дээрх төслийн талаар үргэлжлүүлэн санал, мэдээлэл солилцож ажиллана.

3. Хоёр улсын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа

Өнөөг хүртэлх ололт амжилтууд

Сүүлийн жилүүдэд "Стратегийн түншлэл"-ийн хүрээнд өргөн хүрээтэй эдийн засгийн хамтын ажиллагааг хоёр улс хэрэгжүүлж ирэв.

Япон Улсын Засгийн газрын иенийн хөнгөлөлттэй зээлээр дэд бүтцийн салбарт хэрэгжиж буй "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл"-ийн үндсэн гэрээнд тусгасан барилгын ажил дуусав.

2013 онд иенийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр тохиролцсон "Улаанбаатар хотын 4 дүгээр дулааны цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл"-ийн хүрээнд Япон Улсын техник, технологийг Монгол

Улсын эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх салбарт нэвтрүүлж байна. Мөн хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх зэрэг цэвэр нүүрсний технологийн салбарт Япон Улс боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлж, 2016 оны 6 дугаар сард “Монгол Улсын Уул уурхайн яам, Япон Улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам хооронд цэвэр нүүрсний технологийн салбар дахь хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсэг зурав.

Хоёр улсын Байгаль орчны яам хооронд бодлогын зөвлөлдөх уулзалт 10 удаа болов.

Хоёр улсын Засгийн газар хооронд 2013 онд Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл байгуулах тухай баримт бичигт гарын үсэг зурж, Монгол Улс тус түншлэлийг Япон Улстай байгуулсан анхны орон болсон төдийгүй Хамтарсан кредит олгох механизм (ХКОМ)-ыг хэрэгжүүлэх боломж бүрдсэн билээ. Тус механизмын хүрээнд эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч, усан халаалтын зуухны чиглэлээр төслүүд амжилттай хэрэгжиж байна.

Япон Улсын Засгийн газраас олон улсын байгууллагын шугамаарх сангаар дамжуулан Монгол Улсын ой модыг тогтвортой хамгаалахад дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлэв. Мөн Япон Улсын Засгийн газраас Улаанбаатар хотыг ойжуулах техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлж, Япон Улсын төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих зэргээр Монгол Улсын цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг дэмжиж ирэв.

2014-2015 онд сэргээгдэх эрчим хүчний салбарт төр, хувийн хэвшлийн хамтарсан төсөл хэрэгжүүлэх боломжийг судлав. Мөн 2016 оны 9 дүгээр сард Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхийг хөхиүлэн дэмжих зорилгоор хоёр улсын хувийн хэвшлийнхний хамтарсан төсөлд Япон Улсын Засгийн газар Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)-тай хамтарсан зээл олгов.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлд, уур амьсгалын өөрчлөлтөөс хамааран зуд нүүрлэх магадлалыг нарийвчлан тооцох тогтолцоо болон нийслэл орчмын усны нөөцийг тооцох нарийвчлалыг сайжруулах чиглэлээр Монголын судлаачидтай хамтран дэмжлэг үзүүлж байгаагийн сацуу Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн 2 дугаар шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх талаар хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулж туршлага солилцсон.

Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Япон Улсын Засгийн газар Монгол

Улсын гамшгийн асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны чадавхийг дээшлүүлэхэд техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэв.

2014 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотын бохир усны байгууламжийг шинэчлэн засварлах зэрэг асуудлаар "Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам, Япон Улсын Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яам хооронд дэд бүтцийн салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг" байгуулав. Мөн Улаанбаатар хотын усан хангамж, Дорноговь аймгийн бохир усны дэд бүтцийн менежментийн чадавхийг сайжруулах чиглэлээр Япон Улсын зарим муж, орон нутгаас гаргасан санаачилга, үйл ажиллагааг Япон Улсын Засгийн газраас дэмжиж ажиллав.

Япон Улсын экспортыг хөхиүлэн дэмжиж, Японы аж үйлдвэрийн олон улсад өрсөлдөх чадварыг хадгалж, нэмэгдүүлэх, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор Японы Олон улсын хамтын ажиллагааны банк (ЖБИК) 2013 онд байгуулсан Экспортын зээлийн шугамын ерөнхий хэлэлцээрээр дамжуулан 2015 оны 6 дугаар сар, 2016 оны 10 дугаар сард Монгол Улсын Засгийн газартай тусгайлсан зээлийн гэрээг байгуулж, экспортын зээл олгосноор Монголын аж ахуйн нэгжүүдийн Япон Улсаас техник, тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагааг дэмжив.

Монгол оронтой төстэй уур амьсгалтай Япон Улсын Хоккайдо муж болон Монгол Улсын хооронд төр, хувийн хэвшлийн хамтарсан семинар зохион байгуулах зэрэг өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хэрэгжүүлж, Хоккайдо мужийн туршлагыг хуваалцаж, тус мужийн хувийн хэвшлийнхэн техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэв. Энэхүү хамтын ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын хөгжил төдийгүй хоёр улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн бус байгууллага хоорондын харилцааг бэхжүүлж, Хоккайдо мужийн хувийн хэвшлийнхэн Монгол Улсын зах зээлд байр сууриа олоход нь хувь нэмэр оруулав.

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

(1) Хоёр улсын Засгийн газар 2016 оны 6 дугаар сард хүчин төгөлдөр болсон Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн 15 дугаар зүйлд тулгуурлан дараах салбарт хамтын ажиллагааг өгөөжтэй, үр ашигтай хэрэгжүүлнэ.

А. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загасны аж ахуй

Б. Аж үйлдвэрлэл

В. Жижиг болон дунд үйлдвэрлэл
Г. Худалдаа болон хөрөнгө оруулалт
Д. Дэд бүтэц, барилга, хот байгуулалт
Е. Шинжлэх ухаан, технологи болон оюуны өмч
Ё. Санхүүгийн үйлчилгээ
Ж. Боловсрол болон хүний нөөцийн хөгжил
З. Аялал жуулчлал
И. Байгаль орчин
Й. Уул уурхай болон эрчим хүч
К. Эрүүл мэнд
Л. Өрсөлдөөн
М. Мэдээлэл, харилцаа холбооны технологи
Н. Хоёр улсын Засгийн газар хооронд харилцан тохиролцсон бусад салбар

(2) Япон Улсын Засгийн газрын иенийн хөнгөлөлттэй зээлээр баригдсан Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын үйл ажиллагааны менежментийн гэрээ байгуулах асуудлаар Монгол Улсын Засгийн газраас Япон Улсын консорциумтай явуулж буй яриа хэлэлцээг ойрын хугацаанд тохиролцоонд хүргэх чиглэлд хоёр улсын Засгийн газар дэмжлэг үзүүлнэ. Монголын тал шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад оруулахад гэрээний дагуу ачаа, шуудан тээврийн үйлчилгээ, аэродромын засвар үйлчилгээ болон захиргааны барилгыг барьж дуусгах ажлыг эрчимжүүлж, ангар, катеринг, хурдны замын барилгыг барьж ашиглалтад оруулан шатахуун хангамжийн байгууламжийн үйл ажиллагааг эрхлэн явуулах оператор байгууллага болон ашиглах шатахууны стандартыг ойрын хугацаанд тодорхойлж дуусгана. Мөн хоёр улсын агаарын тээврийн хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх тал дээр хамтран ажиллана.

(3) Хоёр улсын Засгийн газар 2013 онд байгуулсан Японы Олон улсын хамтын ажиллагааны банк (ЖБИК)-ны Экспортын зээлийн шугамын ерөнхий хэлэлцээрт заасны дагуу тусгайлсан зээлийн гэрээнүүдийг байгуулж, зээлийн ерөнхий хэлэлцээрийг зохистой ашиглаж, хэрэгжүүлнэ.

(4) Хоёр улсын Засгийн газар Байгаль орчны яамд хоорондын бодлогын зөвлөлдөх уулзалтыг 10 удаа үр дүнтэй зохион байгуулсныг сайшааж, цаашид энэхүү хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

(5) Хоёр улсын Засгийн газар Монгол Улсад нүүрстөрөгч багатай нийгэм төлөвшүүлэхэд чиглэсэн Хамтарсан кредит олгох механизм (ХКОМ)-ийн

хүрээнд хамтарсан хорооны хурлыг 4 удаа зохион байгуулж, ХКОМ-ын төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэв. Мөн 2016 оны 10 дугаар сард тус механизмын хүрээнд зээл олгогдсон зэрэг үр дүнг сайшааж, төр хувийн хэвшил хамтран ХКОМ-ийн төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

(6) Хоёр улсын Засгийн газар 2015 онд байгуулсан “Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Япон Улсын Байгаль орчны яам хоорондын байгаль орчны салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг”-т тулгуурлан Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөтөлбөрийг батлах, уур амьсгалын өөрчлөлтөөс болж үүсэх нөлөөллийг үнэлэх хамтын ажиллагааг үргэлжлүүлж, уур амьсгалын эрсдлийн мэдээллийг хөгжүүлснээр Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох Ази, Номхон далайн бүс нутгийн мэдээллийн платформыг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулна.

(7) Хоёр улсын Засгийн газар ХКОМ-ийн хүрээнд эхлүүлсэн эрчим хүчний хэмнэлттэй, цахилгаан дамжуулах шугам сүлжээний туршилтын төслийг урагшлуулах чиглэлд хүч чармайлт гаргаж ажиллана. Мөн хоёр улсын Засгийн газар ХКОМ-ийн хүрээнд хэрэгжиж буй нарны эрчим хүчний үүсгүүрээр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх төсөл болон бусад сэргээгдэх эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлд холбогдох яам хооронд мэдээлэл солилцож ажиллана.

(8) Хоёр улсын Засгийн газар 2016 онд гарын үсэг зурсан “Монгол Улсын Уул уурхайн яам, Япон Улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам хооронд цэвэр нүүрсний технологийн салбар дахь хамтын ажиллагааны санамж бичиг”-т тулгуурлан цэвэр нүүрсний технологийн салбарын харилцааг гүнзгийрүүлнэ.

(9) Хоёр улсын Засгийн газар Монгол Улсын нүүрс, зэс, бусад байгалийн эрдэс баялгийг Япон Улсад урт хугацааны турш тогтвортой нийлүүлэх чиглэлд хамтран ажиллана.

(10) Япон Улсын Засгийн газар Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, холбогдох яам, газрын уялдаа холбоог сайжруулах, зохицуулах чадавхийг бэхжүүлж, газар хөдлөлтөд тэсвэртэй барилга барих, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах, асуудал хариуцсан байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх чиглэлд үргэлжлүүлэн хамтран ажиллана.

(11) Хоёр улсын Засгийн газар бүс нутгийн онцлог, давуу талаа ашигласан хоёр улсын хувийн хэвшлийнхний бизнесийн үйл ажиллагаа болон техникийн хамтын ажиллагааг дэмжинэ.

(12) Япон Улсын Засгийн газар Монгол Улсын хөгжлийн бодлого, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэхийн хамт Улаанбаатар хотыг байгаль орчинд ээлтэй, аюулгүй хот болгон хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллана.

(13) Япон Улсын Засгийн газар орон нутаг, хот хоорондын тэнцвэртэй хөгжлийг хөхиүлэн дэмжих үүднээс Улаанбаатар хотын хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны төвлөрлийг сааруулж, бүс нутгийн нөөц бололцоог дайчлан ашиглах замаар Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, стратегийг бэхжүүлэх чиглэлд хамтран ажиллана.

(14) Монгол Улсын Засгийн газар Улаанбаатар хотын 5 дугаар дулааны цахилгаан станцийг барьж байгуулах төсөлд оролцох хүсэлтээ илэрхийлсэн Японы хувийн хэвшил, олон улсын консорциумын өнөөг хүртэл явуулж ирсэн үйл ажиллагаанд анхаарч, талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр холбогдох шийдвэрийг гаргана.

(15) Монгол Улсын тээвэр, логистикийн хөгжлийн асуудлаар санал, мэдээлэл солилцоно.

III. Соёл, иргэд хоорондын харилцаа, хүний нөөцийг бэхжүүлэх хүрээнд харилцан ойлголцол, найрамдал нөхөрлөлийг бататган хөгжүүлэхийн тулд бүх түвшний хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Өнөөг хүртэлх ололт амжилтууд

Япон Улсын Засгийн газраас хэрэгжүүлж ирсэн иргэд солилцооны ЖЕНЕСИС хөтөлбөрийн хүрээнд сүүлийн гурван жилд Монгол Улсын нийт 500 орчим хүүхэд, залуус Япон Улсад зочилж, хоёр улсын ирээдүйн харилцааг авч явах хүүхэд, залуусын нөхөрлөл, харилцан ойлголцол бэхжив.

Япон, Ази тивийн хүүхэд залуусын “Сакура шинжлэх ухааны хөтөлбөр”-ийн хүрээнд сүүлийн гурван жилд Монголын 350 орчим хүүхэд, залуус Япон Улсад зочилж, шинжлэх ухаан, технологийн салбарын солилцоог бэхжүүлэхийн сацуу Япон Улсын шинжлэх ухааны дэвшилтэт технологи, ололт амжилттай танилцав.

Сэтгүүл зүй, судалгаа шинжилгээний салбарын хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлснээр хоёр улсын харилцан ойлголцол улам гүнзгийрэв.

Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын япон хэлний багш сурагчдыг

дэмжиж, Засгийн газрын тэтгэлгээр гадаад оюутныг сургах хөтөлбөрийн хүрээнд монгол оюутнуудыг сургаж байгаа нь харилцан ойлголцлыг нэмэгдүүлэв.

Япон Улсын Засгийн газрын Хөгжлийн албан ёсны буцалтгүй тусламжийн хүрээнд 2015 оны 5 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн “Монгол, Японы сургалтын эмнэлгийн төсөл” зэргээр дамжуулан Монгол Улсын эрүүл мэндийн салбарын үйлчилгээ, эмчилгээний чанарыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах эмнэлгийн боловсон хүчин бэлтгэхэд цогц туслалцаа үзүүлж эхлэв.

Япон Улсын Засгийн газар ардчилал, зах зээлийн нийгмийн тогтолцоонд шилжсэний дараах Монгол Улсын суурь, бүрэн дунд боловсролын орчинг сайжруулах, боловсролын чанарыг дээшлүүлэхэд хамтран ажиллах зэргээр Монгол Улсын хүний нөөцийг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулсаар ирэв.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) болон Монгол Улсын Үндэсний хөгжлийн газраас “Монгол Улсын төр, хувийн хэвшлийн чадавхийг бэхжүүлэх” төслийг хамтран хэрэгжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг үнэлэх, хэрэгжүүлэх тухай гарын авлага гаргав. Уг төслийн хүрээнд энэхүү гарын авлагыг ашиглан Эрүүл мэндийн яамны болон бусад холбогдох яамны ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулав.

Улмаар Япон Улсын Засгийн газар 2015 оноос Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын салбарт дэмжлэг үзүүлж, Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм дэх оролцоог дэмжихэд хамтран ажиллаж ирэв. Монголын Паралимпийн баг тамирчдын урьдчилсан бэлтгэлийг Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага хүлээж авах зэргээр хоёр улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэд хоорондын харилцаа бүх түвшинд хөгжиж эхлэв.

Хоёр улсын орон нутгийн засаг захиргааны байгууллагууд харилцан айлчлал хийх, найрсаг харилцаа, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах зэргээр орон нутгийн засаг захиргааны байгууллага хоорондын харилцаа өргөжин тэлж байна.

Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа

(1) Хоёр улсын Засгийн газар хоёр улсын ирээдүй болсон хүүхэд, залуучуудын харилцааг гүнзгийрүүлэхийн ач холбогдлыг ухамсарлаж, хүүхэд, залуучуудын

солилцоог дэмжих бодлогыг үргэлжлүүлнэ.

(2) Хоёр улсын Засгийн газар хоёр улсын түүх, соёл, соёлын өв болон улс төр, эдийн засаг, нийгмийн байдлыг хоёр улсын ард түмэнд таниулан сурталчлахад чиглэсэн хамтын ажиллагааг харилцан дэмжинэ. Энэ хүрээнд судлаач, сэтгүүлчдийг харилцан солилцох, хэвлэмэл материал, дүрс бичлэг солилцох зэрэг чиглэлээр хамтран ажиллана.

(3) Хоёр улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам хооронд 2017 оны 2 дугаар сарын 14-нд байгуулсан Хамтын ажиллагааны Санамж бичигт тулгуурлан боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар дахь иргэд, хүний нөөцийн солилцоог хөгжүүлэх зэргээр хамтын ажиллагааг бэхжүүлэхийг зорино.

(4) Хоёр улсын Засгийн газар Япон Улс дахь монгол судлал, Монгол Улс дахь япон судлалыг хөгжүүлэхэд хамтран ажиллаж, хоёр улсын эрдэм шинжилгээний салбарын эрдэмтэн, судлаачид хоорондын хамтын ажиллагааг дэмжинэ.

(5) Япон Улсын Засгийн газар Монгол Улс дахь япон хэлний сургалтыг хөгжүүлэх үүднээс тус улсын япон хэлний багш, оюутан сурагчдыг үргэлжлүүлэн дэмжинэ. Монгол Улсын Засгийн газар Монгол дахь япон хэлний сургалтыг дэмжих хүрээнд Япон Улсын холбогдох орон нутгийн засаг захиргааны болон боловсролын байгууллага, найрамдлын нийгэмлэгүүдийн санаачилга, хүчин чармайлтыг дэмжинэ.

(6) Хоёр улсын Засгийн газар соёл, шинжлэх ухаан, техник технологи, соёл, урлагийн салбарын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, холбогдох яам, байгууллага хоорондын харилцааг хөгжүүлэхэд хамтран ажиллана.

(7) Хоёр улсын Засгийн газар орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, ард иргэдийн зүгээс санаачилсан бүхий л солилцоо, санаачлагыг дэмжинэ.

(8) Хоёр улсын Засгийн газар хоёр талын аялал жуулчлалыг дэмжиж, аялал жуулчлалын мэдээллийг харилцан солилцож, сурталчлах чиглэлээр хамтран ажиллана.

(9) Япон Улсын Засгийн газар Монгол Улсын суурь, бүрэн дунд боловсролын сургалтын орчин, боловсролын чанарыг сайжруулах хамтын ажиллагааг үргэлжлүүлнэ.

(10) Япон Улсын Засгийн газар “Хүний нөөцийн хөгжлийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр (ЖДС)”-өөр дамжуулан Монгол Улсын хөгжлийн асуудлыг

шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах шилдэг боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлж, иргэд хоорондын хэлхээ холбоог гүнзгийрүүлнэ.

(11) Япон Улсын Засгийн газар эдүгээ баригдаж буй "Монгол, Японы сургалтын эмнэлэг"-ийн төсөл болон эрүүл мэндийн салбарт ажиллагсдын төгсөлтийн дараах сургалтын тогтолцооны шинэчлэл зэргээр дамжуулан Монгол Улсын эрүүл мэндийн салбарын боловсон хүчин бэлтгэн хөгжүүлэхэд хамтран ажиллана.

(12) Хоёр улсын Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан боловсролын чанарыг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс "өвсний үндэс"-ний түвшний хамтын ажиллагааг дэмжинэ. Мөн хоёр улсын Засгийн газар 2020 оны Токиогийн Паралимпийн наадам болохтой холбогдуулан хоёр улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжихэд чиглэсэн солилцоо, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

(13) Хоёр улсын Засгийн газар 2020 оны Токиогийн Олимп, Паралимпийн наадмыг зохион байгуулах болсонтой холбогдуулан Япон Улсын Засгийн газраас санаачилсан "Маргаашийн төлөөх биеийн тамир" хөтөлбөр, "Хүлээн авагч хот" санаачлага зэрэгт тулгуурлан, спортын солилцоог идэвхжүүлнэ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**Ц.МӨНХ-ОРГИЛ
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

**Ф.КИШИДА
ГАДААД ХЭРГИЙН САЙД**